

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙДЫН ТУШААЛ**

2017 оны ...-р сарын ...-ний өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн 7.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Монгол Улсын хилээр хүүхдийг нэвтрүүлэх журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Журмыг хэрэгжүүлж ажиллахыг Хил хамгаалах ерөнхий газрын дарга, хошууч генерал Ц.Сэргэлэнд даалгасугай.
3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Э.Энхтуяад үүрэг болгосугай.

САЙД

С.БЯМБАЦОГТ

Хууль зүй, дотоод хэргийн
сайдын 2017 оны дугаар
тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР ХҮҮХДИЙГ НЭВТРҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь Монгол Улсын иргэн хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, түүнд хяналт тавих үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэ журам нь гадаадад зорчих Монгол Улсын иргэн 18 нас хүртэлх хүүхдэд хамаарна.

Хоёр. Улсын хилээр нэвтрүүлэх үйл ажиллагаа

2.1. Хүүхдийг хил нэвтрэх эрхийн баримт бичгээс гадна дараах баримт бичгийн аль тохирохыг үндэслэн улсын хилээр нэвтрүүлэх бөгөөд зөвхөн Монгол Улсаас гарах чиглэлд хамаарна.

2.1.1. Эцэг, эхийн аль нэгээр овоглоогүй бол гэр бүлийн гишүүний хамт зорчих үед төрсний гэрчилгээ, түүнийг орлох баримт бичиг /төрсний гэрчилгээний нотариатоор баталгаажуулсан хуулбар, цахим лавлагаа/;

2.1.2. Хүүхдийн хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг тогтоосон тухай сум, дүүргийн засаг даргын захирамж, шүүхийн шийдвэр;

2.1.3. Эцэг, эх буюу хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс өөр хүний хамт гадаадад зорчих хүүхдэд эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хүүхдийн хамт хилээр нэвтрэх этгээдийн хооронд хийсэн нотариатаар гэрчлүүлсэн итгэмжлэл;

2.1.4. Нисэхийн авиакомпаний хүргэлтийн үйлчилгээг авсан нислэгийн тийз.

2.2. Хүүхдийн өөрийнх нь болон хамт явах хүний хил нэвтрэх эрхийн баримт бичиг, зорчих улсын хүчинтэй виз, хүүхдийн эцэг, эх болон гэр бүлийн гишүүний баримт бичгийн хуулбарыг тэдний бичгээр гаргасан үндэслэл бүхий тайлбар бусад нотлох баримт бичгийг итгэмжлэлд хавсаргасан байна. Тухайн хүүхдийн эцэг, эх нь гадаадад байгаа бол Гадаад хэргийн ямаар дамжуулан ирүүлсэн итгэмжлэл байна.

2.3. Гадаад улсад зорчих хүүхдийн хилээр нэвтрэх эрхийн баримт бичиг болон энэ журмын 2.1.1, 2.1.2, 2.1.3-т заасан баримт бичгүүдийн 1 хувийг хилийн боомтод хураан авч, архивын нэгж болгон 3 хүртэл жилийн хугацаагаар хадгална.

2.4. Насанд хүрээгүй хүүхдийн хамт хил нэвтэрсэн этгээд нь хүүхдийг гадаад улсад үлдээсэн тохиолдолд гадаад улсад байгаа эцэг, эх болон бусад хүлээн авсан хүний баримт бичгийн хуулбар, хүүхдийг хүлээн авсан тухай тэмдэглэл, хаяг, холбоо барих утасны дугаар, цахим шуудангийн хаягийн мэдээлэл, баримтыг авчирна. Энэ тухай хилийн шалган нэвтрүүлэх албаны ажилтан тухайн этгээдэд сануулна.

2.5. Гадаадад зорчих хүүхдийн нотлох баримт бичгүүдийг хуурамчаар бүрдүүлсэн болон бусад үндэслэлээр хил дамжуулан худалдагдаж болзошгүй сэжиг илэрвэл цагдаагийн байгууллагад шалгуулахаар шилжүүлнэ.

Гурав. Хүүхдийн Монгол Улсын хилээр нэвтэрсэн талаархи бүртгэл

3.1. “Эцэг, эх болон хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс өөр хүний хамт гадаадад зорчсон хүүхдийн талаарх мэдээлэл”-ийн нэгдсэн сан бүрдүүлнэ.

3.2. Гадаад улсад зорчих хүүхэд ганцаараа, эсвэл хамт яваа хүн нь энэ журмын 2.1.1, 2.1.2, 2.1.3, 2.1.4-д заасан баримт бичиггүй тохиолдолд улсын хилээр нэвтрүүлэхгүй буцааж, энэ талаарх зөрчлийг мэдээллийн санд бүртгэнэ.

3.3. Гадаад улсад зорчих хүүхдийг бүртгэх явцад тухайн хүүхдийн гадаадад зорчих зорилго, хүлээн авагч тодорхойгүй бол хилээр нэвтрүүлэхгүй байж болно.

3.5. Нислэгийн авиакомпанийн хүргэлтийн үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн талаар мэдээллийн санд бүртгэнэ.

3.6. Хилийн боомтод бүртгэгдсэн зөрчлийн судалгааг сар бүр Цагдаагийн байгууллага болон хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус хүргүүлнэ.

Дөрөв. Гадаадад зорчсон хүүхдийн буцаж ирсэн эсэхэд тавих хяналт

4.1. Эцэг, эх буюу хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс өөр хүний хамт гадаадад зорчсон, буцаж ирсэн эсэхэд цагдаа болон хил хамгаалах байгууллага мэдээлэл солилцон, хамтран хяналт тавина.

4.2. Улсын хилээр хамт нэвтэрсэн насанд хүрээгүй хүнийг хилийн гадна үлдээсэн тохиолдолд эргэж ирээгүй шалтгааныг нь тодруулах, шаардлагатай гэж үзвэл тухайн асуудлыг цагдаагийн байгууллагад шалгуулахаар шилжүүлнэ.

4.3."Монгол Улсын хилээр нэвтэрсэн зорчигч, тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн системийн үйл ажиллагааг зохион байгуулах журам"-ын дагуу Хил хамгаалах байгууллага, Цагдаагийн байгууллагатай харилцан мэдээлэл солилцоно.

---o O o---